



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/238.

Чингис хот

Зохион байгуулалтын
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64, 102 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн №20 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар /КОВИД-19/-т цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд сунгасугай.

2. Улсын Онцгой комиссоос “Коронавирусийн халдвар /Ковид-19/-т цар тахлын үеийн харилцан ажиллагаа хариу арга хэмжээ” сэдэвт гамшгаас хамгаалах команд штабын цахим дадлага сургуулийн бэлтгэл ажлыг хангаж оролцохыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Иог, фитнесийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлж, холбогдох дүрэм журам тавигдах шаардлагыг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Гэрэлмаа/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА